

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ҮҮРЭГТ АЖЛААС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2019 оны 11 дүгээр
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Содномдаржаагийн Даваасүрэн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасантай холбогдуулан Улсын Их Хурлын даргаас ирүүлсэн чөлөөлөх саналыг Эдийн засгийн байнгын хорооны 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэнг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36¹ дугаар зүйлийн 36¹.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоолын төслийг боловсруулж, С.Даваасүрэнгийн өргөдөл, Монгол Улсын Их Хурлын даргын саналын хамт Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

С.Даваасүрэнг Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ж.ГАНБААТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

**Санхүүгийн зохицуулах хорооны даргын
үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Содномдаржаагийн Даваасүрэнг өөрийн нь гаргасан хүсэлтийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
http://www.parliament.mn


2019. 11. 05 № 1/11926

танай _____-ны № _____-т

Санхүүгийн зохицуулах хорооны даргыг
албан тушаалаас чөлөөлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн тул Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг оруулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

ДАРГА:  Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын дарга Г Занданшатар танаа

өргөдөл гаргах нь

2019-11-05

Улаанбаатар хот

Миний бие Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 18 тоот тогтоолоор Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргаар томилогдон өнөөг хүртэл ажиллаж байгаа билээ.

Өнгөрсөн гурван жил гаруй хугацаанд төрийн өндөр албан тушаалтны нэр төр, эрхэм чанар, өндөр хариуцлагыг гүнээ ухамсарлан Хорооны хуулиар хүлээсэн, банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын бодлого зохицуулалт, хянан шалгалтын үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд өөрийн мэдлэг мэргэшил, удирдах ажилтны салбараа болон хамт олноо удирдах ур чадвараа дайчлан хоёргүй сэтгэлээр ажиллаж Монгол улсын үнэт цаас, даатгалын зах зээл болон бичил санхүүгийн байгууллагуудын хэтийн бодлого зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлж, банкнаас бусад салбарыг 200 хувь өсгөж чадлаа.

Энэхүү өндөр өсөлт Монгол улсын санхүүгийн салбарын сүүлийн 30 жилийн түүхэнд байгаагүй ахиц дэвшил бөгөөд өнөөдөр ч бусад салбарт гараагүй болохыг түүх гэрчилнэ.


Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын байгууллагаас манай улсын 2013-2016 оны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Санхүүгийн Зохицуулах Хороо 2017 оноос эхлэн ханган ажиллахад миний бие хамт олноо удирдан зохион байгуулах, биелэлтийг хянан шалгах, авч хэрэгжүүлж буй арга хэмжээг үр дүнд хүргэхийн төлөө бүхий л хүч, ур чадвараа дайчлан ажиллаж зохих үр дүнд хүргэсэн билээ.

Монгол улсыг “саарал жагсаалт”-д оруулахдаа ФАТФ-аас өгсөн дөрвөн зөвлөмжид Санхүүгийн Зохицуулах Хороонд холбогдуулан өгсөн асуудал тусгагдаагүй бөгөөд Монгол улсад хуулиар зохицуулалтгүй байгаа санхүүгийн бус бизнес болох үнэт эдлэл, үнэт чулуу, үл хөдлөх хөрөнгийн бизнесийн хяналт зохицуулалтыг СЗХ хэрэгжүүлэхээр саяхан шинээр хууль баталж, хэрэгжүүлэх ажил эхлээд байна.

Мөн тэрчлэн Санхүүгийн Зохицуулах Хороо нь хамтын удирдлагатай аливаа асуудлыг Хорооны хурлаар олонхын саналаар шийдвэрлэдэг тул хариуцлага тооцох асуудалд Хорооны орон тооны бусад гишүүд ч хамааралтай гэж үзэж байгаа болно.

Иймд С.Даваасүрэн миний бие Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргын хувьд үүсэж буй нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн хүсэлтээр Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргын ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байгааг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

Өргөдөл гаргасан



Доктор С.Даваасүрэн